

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	11
3. Аудитын тайлан.....	12
3.1. Ерөнхий зүйл.....	12
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	12
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт	13
3.4. Материаллаг байдал	13
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	13
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	14
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	15
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
3.9. Аудитын илрүүлэлт.....	15
Залруулсан алдаа.....	16
Аудитын зөвлөмж.....	16
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	16
4. Менежментийн захидал	17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	19



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2021.02.25 № 07/515
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эмгэг судлалын үндэсний төвийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Эмгэг судлалын үндэсний төвийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд Эрүүл мэндийн дэмжих сангийн санхүүжилтээр 3 төсөл хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 100.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>7,546,129.38</u>	<u>14,940,004.13</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	7,546,129.38	14,940,004.13
351	Түүхий эд материал	6,820,000.00	8,672,334.50
35110	Тусгай зориулалттай материал	6,820,000.00	8,672,334.50
354	Хангамжийн материал	726,129.38	6,267,669.63
35410	Бичиг хэргийн материал	-	848,140.00
35420	Аж ахуйн материал	-	4,085,810.00
35440	Түлш, шатах тослох материал	726,129.38	1,333,719.63
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>949,529,638.80</u>	<u>936,015,921.74</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	949,529,638.80	936,015,921.74
391	Газар		
392	Биет хөрөнгө	948,493,805.45	935,206,088.35
39201	Барилга, байгууламж, орон сууц	584,190,200.00	584,190,200.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(16,227,505.56)	(32,918,654.16)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	55,207,000.00	65,365,188.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(36,040,333.33)	(15,717,822.67)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,032,076,896.80	1,183,692,776.60
39206	Хуримтлагдсан элэгдэл	(710,288,522.71)	(892,114,697.82)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	71,027,350.00	67,009,400.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(31,451,279.75)	(24,300,301.60)
393	Биет бус хөрөнгө	1,035,833.35	809,833.39
39301	Програм хангамж	1,130,000.00	1,130,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(94,166.65)	(320,166.61)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>957,075,768.18</u>	<u>950,955,925.87</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>957,075,768.18</u>	<u>950,955,925.87</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	957,075,768.18	950,955,925.87
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	368,401,756.70	368,401,756.70
51101	Өмч: - төрийн	368,401,756.70	368,401,756.70
512	Хуримтлагдсан үр дүн	324,317,101.33	318,197,259.02
51210	Өмнөх үеийн үр дүн	385,961,492.92	324,317,101.33
51220	Тайлант үеийн үр дүн	(61,644,391.59)	(6,119,842.31)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	264,356,910.15	264,356,910.15
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>957,075,768.18</u>	<u>950,955,925.87</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,683,503,604.34	1,954,319,287.13
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	328,106,804.34	474,076,947.13
120	Нийтлэг татварын бус орлого	328,106,804.34	474,076,947.13
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	328,106,804.34	474,076,947.13
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	209,500,200.00	277,059,511.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	118,606,604.34	197,017,436.13
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,355,396,800.00	1,480,242,340.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,304,093,900.00	1,398,010,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,304,093,900.00	1,398,010,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	51,302,900.00	82,231,740.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	6,500,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	44,178,900.00	25,827,140.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	624,000.00	56,404,600.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,745,122,218.09	1,960,365,212.70
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,745,122,218.09	1,960,365,212.70
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,593,948,084.17	1,842,253,911.84
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	875,398,278.95	995,120,016.10
210101	Үндсэн цалин	688,865,076.95	598,621,441.28
210102	Нэмэгдэл	68,316,880.00	221,492,564.18
210103	Унаа хоолны хөнгөлөлт	118,216,322.00	92,921,152.54
210104	Урамшуулал	-	82,084,858.10
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	118,578,823.41	139,195,178.50
210201	Тэтгэврийн даатгал	76,376,101.41	82,193,618.66
210202	Тэтгэмжийн даатгал	8,872,197.00	17,517,523.67
210203	ҮОМШӨ-ний даатгал	16,071,800.00	17,194,343.82
210204	Ажилгүйдлийн даатгал	1,562,090.00	2,021,081.39
210205	Эрүүл мэндийн даатгал	15,696,635.00	20,268,610.96
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	51,351,000.00	50,139,200.00
210301	Гэрэл, цахилгаан	25,087,807.00	12,150,300.00
210302	Түлш, халаалт	12,182,700.00	14,619,200.00
210303	Цэвэр, бохир ус	13,780,493.00	17,873,700.00
210304	Байрны түрээс	300,000.00	5,496,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	26,911,283.00	59,306,747.14
210401	Бичиг хэрэг	4,392,862.50	7,748,580.00
210402	Тээвэр, шатахуун	6,036,607.22	7,284,219.75
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,445,963.28	3,903,867.39
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	6,762,390.00	33,781,666.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,273,460.00	6,588,414.00

2105	Нормативт зардал	222,720,918.19	303,746,953.63
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	213,160,909.19	288,405,353.63
210502	Хоол, хүнс	1,872,790.00	4,787,100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	7,687,219.00	10,554,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,436,220.00	16,911,647.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,389,400.00	11,540,000.00
210604	Урсгал засвар	10,046,820.00	5,371,647.00
2107	Томилолт, зочны зардал	22,580,200.00	7,338,799.00
210701	Гадаад албан томилолт	8,393,400.00	-
210702	Дотоод албан томилолт	14,186,800.00	7,338,799.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	24,317,120.00	34,690,402.15
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,600,000.00	15,725,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	10,906,500.00	5,452,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	414,920.00	2,189,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	74,500.00	158,400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	39,600.00	75,457.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,281,600.00	10,249,595.15
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	-	840,750.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	237,654,240.62	235,804,968.32
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	26,485,417.25	9,614,336.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	211,168,823.37	226,190,632.32
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	151,174,133.92	118,111,300.86
2132	Бусад урсгал шилжүүлэг	44,573,527.50	61,165,600.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	20,585,300.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	20,380,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	44,573,527.50	20,200,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	106,600,606.42	56,945,700.86
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	106,600,606.42	56,945,700.86
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(61,618,613.75)	(6,045,925.57)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	25,777.84	73,916.74
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	25,777.84	73,916.74
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(25,777.84)	(73,916.74)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(61,644,391.59)	(6,119,842.31)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>1,564,897,000.00</u>	<u>1,757,301,851.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	209,500,200.00	277,059,511.00
120	Нийтлэг татварын бус орлого	209,500,200.00	277,059,511.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	209,500,200.00	277,059,511.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	209,500,200.00	277,059,511.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,355,396,800.00	1,480,242,340.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,304,093,900.00	1,398,010,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,304,093,900.00	1,398,010,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	51,302,900.00	82,231,740.00
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл	6,500,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	44,178,900.00	25,827,140.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	624,000.00	56,404,600.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>1,530,450,351.00</u>	<u>1,715,831,651.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,530,450,351.00	1,715,831,651.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,379,212,335.08	1,597,720,350.14
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	874,447,387.95	995,120,016.10
210101	Үндсэн цалин	579,426,990.79	598,621,441.28
210102	Нэмэгдэл	156,743,644.16	221,492,564.18
210103	Унаа хоолны хөнгөлөлт	80,850,000.00	92,921,152.54
210104	Урамшуулал	57,426,753.00	82,084,858.10
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	118,373,336.41	139,195,178.50
210201	Тэтгэврийн даатгал	75,688,265.94	82,193,618.66
210202	Тэтгэмжийн даатгал	9,610,600.00	17,517,523.67
210203	ҮОМШӨ-ний даатгал	15,290,478.00	17,194,343.82
210204	Ажилгүйдлийн даатгал	1,545,000.00	2,021,081.39
210205	Эрүүл мэндийн даатгал	16,238,992.47	20,268,610.96
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	51,351,000.00	50,139,200.00
210301	Гэрэл, цахилгаан	32,744,500.00	12,150,300.00
210302	Түлш, халаалт	12,182,700.00	14,619,200.00
210303	Цэвэр, бохир ус	6,123,800.00	17,873,700.00
210304	Байрны түрээс	300,000.00	5,496,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	24,564,403.28	54,370,806.39
210401	Бичиг хэрэг	5,925,100.00	7,450,140.00
210402	Тээвэр, шатахуун	5,597,000.00	7,718,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,897,563.28	3,450,667.39
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	9,735,100.00	34,161,099.00

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,409,640.00	1,590,700.00
2105	Нормативт зардал	221,004,369.19	283,571,444.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	211,130,075.86	266,843,044.00
210502	Хоол, хүнс	2,033,000.00	4,787,100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	7,841,293.33	11,941,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,964,849.00	21,168,750.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,208,050.00	12,940,000.00
210604	Урсгал засвар	10,756,799.00	8,228,750.00
2107	Томилолт, зочны зардал	22,591,240.00	7,338,799.00
210701	Гадаад албан томилолт	8,393,400.00	-
210702	Дотоод албан томилолт	14,197,840.00	7,338,799.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	25,633,520.00	36,285,852.15
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,600,000.00	15,725,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	10,906,500.00	5,452,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	414,920.00	2,189,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	74,500.00	158,400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	39,600.00	75,457.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,098,000.00	11,185,795.15
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,500,000.00	1,500,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	26,282,229.25	10,530,304.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	26,282,229.25	10,530,304.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	151,238,015.92	118,111,300.86
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	44,637,409.50	61,165,600.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	20,585,300.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	20,380,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	44,637,409.50	20,200,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	106,600,606.42	56,945,700.86
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	106,600,606.42	56,945,700.86
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>34,446,649.00</u>	<u>41,470,200.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	34,446,649.00	41,470,200.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	34,446,649.00	41,470,200.00
2200	Дотоод эх үүсвэрээр	34,446,649.00	41,470,200.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	34,446,649.00	41,470,200.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(34,446,649.00)</u>	<u>(41,470,200.00)</u>
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	368,401,756.70	264,356,910.15	385,961,492.92	1,018,720,159.77
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	368,401,756.70	264,356,910.15	385,961,492.92	1,018,720,159.77
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(61,644,391.59)	(61,644,391.59)
D01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	368,401,756.70	264,356,910.15	324,317,101.33	957,075,768.18
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	368,401,756.70	264,356,910.15	324,317,101.33	957,075,768.18
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(6,119,842.31)	(6,119,842.31)
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	368,401,756.70	264,356,910.15	318,197,259.02	950,955,925.87

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,666,641,000.00	1,618,126,254.80	48,514,745.20	97.09
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,666,641,000.00	1,618,126,254.80	48,514,745.20	97.09
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,628,060,700.00	1,579,545,954.80	48,514,745.20	97.02
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,030,260,500.00	983,788,700.20	46,471,799.80	95.49
210101	Үндсэн цалин	630,057,200.00	587,290,125.38	42,767,074.62	93.21
210102	Нэмэгдэл	224,844,800.00	221,492,564.18	3,352,235.82	98.51
210103	Унаа хоолны хөнгөлөлт	80,850,000.00	92,921,152.54	(12,071,152.54)	114.93
210104	Урамшуулал	94,508,500.00	82,084,858.10	12,423,641.90	86.85
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	139,085,100.00	137,696,309.50	1,388,790.50	99.00
210201	Тэтгэврийн даатгал	87,572,100.00	80,694,749.66	6,877,350.34	92.15
210202	Тэтгэмжийн даатгал	10,302,600.00	17,517,523.67	(7,214,923.67)	170.03
210203	ҮОМШӨ-ний даатгал	18,544,700.00	17,194,343.82	1,350,356.18	92.72
210204	Ажилгүйдлийн даатгал	2,060,500.00	2,021,081.39	39,418.61	98.09
210205	Эрүүл мэндийн даатгал	20,605,200.00	20,268,610.96	336,589.04	98.37
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	50,139,200.00	50,139,200.00	-	100.00
210301	Гэрэл, цахилгаан	12,150,300.00	12,150,300.00	-	100.00
210302	Түлш, халаалт	14,619,200.00	14,619,200.00	-	100.00
210303	Цэвэр, бохир ус	17,873,700.00	17,873,700.00	-	100.00
210304	Байрны түрээс	5,496,000.00	5,496,000.00	-	100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	25,676,200.00	26,215,149.95	(538,949.95)	102.10
210401	Бичиг хэрэг	4,646,500.00	4,646,500.00	-	100.00
210402	Тээвэр, шатахуун	7,718,200.00	7,718,200.00	-	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,652,700.00	1,670,600.95	(17,900.95)	101.08
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	10,209,000.00	10,730,049.00	(521,049.00)	105.10
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,449,800.00	1,449,800.00	-	100.00
2105	Нормативт зардал	285,626,300.00	285,625,494.00	806.00	100.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	272,685,000.00	272,684,194.00	806.00	100.00
210502	Хоол, хүнс	1,000,000.00	1,000,000.00	-	100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	11,941,300.00	11,941,300.00	-	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	54,397,800.00	53,858,850.00	538,950.00	99.01

210601	Багаж, техник, хэрэгсэл	45,630,100.00	45,630,100.00	-	100.00
210604	Урсгал засвар	8,767,700.00	8,228,750.00	538,950.00	93.85
2107	Томилолт, зочны зардал	5,924,000.00	5,923,999.00	1.00	100.00
210702	Дотоод албан томилолт	5,924,000.00	5,923,999.00	1.00	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	36,951,600.00	36,298,252.15	653,347.85	98.23
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	15,725,000.00	15,725,000.00	-	100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	6,041,400.00	5,452,200.00	589,200.00	90.25
210803	Даатгалын үйлчилгээ	2,189,000.00	2,189,000.00	-	100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	158,400.00	158,400.00	-	100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	139,600.00	75,457.00	64,143.00	54.05
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	11,198,200.00	11,198,195.15	4.85	100.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,500,000.00	1,500,000.00	-	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	38,580,300.00	38,580,300.00	-	100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	38,580,300.00	38,580,300.00	-	100.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	20,380,300.00	20,380,300.00	-	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	18,200,000.00	18,200,000.00	-	100.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,666,641,000.00	1,618,126,254.80	48,514,745.20	97.09
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,398,010,600.00	1,341,066,743.80	56,943,856.20	95.93
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,398,010,600.00	1,341,066,743.80	56,943,856.20	95.93
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	268,630,400.00	277,059,511.00	(8,429,111.00)	103.14
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	268,630,400.00	277,059,511.00	(8,429,111.00)	103.14
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	-
1	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100.00
610001	Төсвийн байгууллага	1	1	-	100.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	70	65	5	92.86
620001	Удирдах ажилтан	1	1	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	52	54	(2)	103.85
620003	Үйлчлэх ажилтан	17	10	7	58.82

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		82,229,895.34
21	УРСГАЛ ЗАРДАЛ		82,229,895.34
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		59,644,595.34
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		11,331,315.90
210101	Үндсэн цалин		11,331,315.90
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		1,498,869.00
210201	Тэтгэврийн даатгал		1,498,869.00
2104	Хангамж, бараа материалын зардал		28,694,606.44
210401	Бичиг хэрэг		2,803,640.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		1,780,066.44
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		23,970,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		140,900.00
2105	Нормативт зардал		5,287,100.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		1,500,000.00
210502	Хоол, хүнс		3,787,100.00
2107	Томилолт, зочны зардал		1,414,800.00
210702	Дотоод албан томилолт		1,414,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		887,600.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		887,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		10,530,304.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		10,530,304.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		22,585,300.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		22,585,300.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		20,585,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		2,000,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг		1,844.66
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг		1,844.66
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		82,231,740.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		82,231,740.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		25,827,140.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		56,404,600.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Эмгэг судлалын үндэсний төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг захирал Г.Уянга танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд өөрийн хөрөнгө буюу засгийн газрын оруулсан капитал, биет бус хөрөнгийн элэгдлийн тооцоо болон татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-наас 2021 оны 01 дүгээр сарын 18-ны хооронд Үндэсний аудитын газрын захиалгаар “Акпар-Аудит” компанийн захирал Х.Баянбай, аудитор М.Хосбаяр, чанарын хяналтын менежер Д.Хишигсүрэн, аудиторов туслах И.Халиунаа нар хариуцаж хэрэгжүүлэв.

Эмгэг судлалын үндэсний төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг “Акпар-Аудит” ХХК-д 2021 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 36 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Эмгэг судлалын үндэсний төвийн үйл ажиллагааны эрхэм зорилгыг “Эмгэг судлалын тусламж, үйлчилгээг үндэсний хэмжээнд чанар, хүртээмжийг байнга сайжруулж, олон улсын түвшинд хүргэхэд оршино” гэж тодорхойлсон.

Эмгэг судлалын үндэсний төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Эмчлэгдэж байгаад нас барсан тохиолдолд эмгэг судлалын задлан шинжилгээ хийж, эмчилгээ оношлогооны тохиргоог шалган баталж, клиникийн эмч нарын мэдлэг мэргэжил хариуцлагыг дээшлүүлэх;
- Онош зөрсөн ховор тохиолдолд эмгэг судлал эмнэл зүйн эмч нарын хамтарсан зөвлөгөөнийг хийж эмчилгээ үйлчилгээний доголдол, дутагдлыг шүүн хэлэлцэх;
- Орон нутгийн мэргэжил нэгт эмч нарт мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх;
- Өвчтөнөөс авсан амьд сорьц, эсийн түрхцэд эд, эс химийн шинжилгээ хийх, оношлох;

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- “Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай” хуулийг хэрэгжүүлэн ажилласан.
- Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 472 дугаар тогтоолыг үндэслэн 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс нийт ажиллагсдын үндсэн цалинг шинэчлэн тогтоосон.

- Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын “Журам батлах тухай” 382 дугаар тогтоолыг баримтлан эмч, эмнэлгийн ажилтнуудын нэмэгдэл, нэмэгдэл хөлсийг олгодог. 2020 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 151 дүгээр тогтоолоор дээрх тогтоолд орсон нэмэлт өөрчлөлтийг үйл ажиллагаандаа мөрдөн ажилласан;

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Эмгэг судлалын үндэсний төвийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Эрүүл мэндийн яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар 2020 онд тус төвийн 2018, 2019 оны санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд дотоод аудит хийсэн байна.

Дотоод аудитын шалгалтаар материаллаг алдаа зөрчил илрээгүй тул төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмж өгөөгүй байна.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны үр дүнгийн тайлангийн нийт орлогын 1,683,503.6 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 33,670.1 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Эмгэг судлалын үндэсний төвийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 6,119.8 мянган төгрөгөөр буюу 0.6 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

	/мянган төгрөг/		
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Бараа материал	7,546.1	14,940.0	7,393.9
Үндсэн хөрөнгө	949,529.6	936,015.9	(13,513.7)
Нийт хөрөнгө	957,075.7	950,955.9	(6,119.8)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	957,075.7	950,955.9	(6,119.8)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	957,075.7	950,955.9	(6,119.8)

Бараа материалын дансны үлдэгдэл 14,941.0 мянган төгрөг болж 7,393.9 мянган төгрөгөөр өссөн нь Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/516 дугаартай тушаал, 23 дугаартай албан даалгаврын дагуу хандиваар ирсэн хөрөнгө болон батлагдсан төсвийн хүрээнд хөдөлмөр хамгааллын хэрэгсэл, норм хувцас, эм, эмнэлгийн хэрэгсэл, шатахууны нөөц бүрдүүлснээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 936,015.9 мянган төгрөг болж, 13,513.7 мянган төгрөгөөр буурсан нь дараах нөхцөл байдлаас шалтгаалжээ. Үндсэн хөрөнгө нь дахин үнэлгээгээр 8,090.6 мянган төгрөг, урсгал төсвийн худалдан авалтаар 41,470.2 мянган төгрөг, хандиваар болон үнэ төлбөргүй шилжиж ирсэн хөрөнгийн 163,190.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн боловч акталсан үндсэн хөрөнгийн 11,019.8 мянган төгрөг, дахин үнэлгээний үнийн хорогдлоор 8,767.9 мянган төгрөг, тайлант онд байгуулсан болон хасагдсан үндсэн хөрөнгийн элэгдлийн зөрүүнээс болж 206,476.8 мянган төгрөгөөр тус тус буурсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 950,955.9 мянган төгрөг болж 6,119.8 мянган төгрөгөөр буурсан нь дээрх эргэлтийн болон эргэлтийн бус хөрөнгийн өсөлт, бууралтаас шалтгаалжээ.

Эмгэг судлалын үндэсний төвийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 270,815.7 мянган төгрөгөөр буюу 16.1 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь батлагдсан урсгал зардлын санхүүжилт болон нэмэлт санхүүжилтийн хэмжээ нэмэгдэж, өөрийн үйл ажиллагааны орлого өссөнтэй холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 215,243.0 мянган төгрөгөөр буюу 12.3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь цалин хөлс, эм эмнэлгийн хэрэгсэл хоол хүнс, нормын хувцас, багаж хэрэгслийн зардлууд байна. Энэ нь цар тахалтай холбоотой нэмэгдэл хөлс, хамгаалах хэрэгсэл, эм, эмнэлгийн хэрэгслүүдийн төсвийг нэмж, нөөц бүрдүүлж эхэлсэнтэй холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан, залруулсан зүйл байхгүй байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус төвийн 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,291,482.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Захирагчийн хүргүүлсэн нийт төсвийг 375,158.8 мянган төгрөгөөр, үүнээс үндсэн үйл ажиллагааны орлогыг 203,130.4 нэмэгдүүлж, 1,666,641.0 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийг нэмэгдүүлж баталсан нь цар тахалтай тэмцэхэд нэмэгдэл зардал гарах, мөн хамгаалах хэрэгслийн нөөц бүрдүүлэх шаардлагатай болсонтой холбоотой байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрийн арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,398,010.6 мянган төгрөгийг улсын төсвөөс 268,630.4 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,398,010.6 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 277,059.5 мянган төгрөг, нийт 1,675,070.10 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 1,618,126.2 мянган төгрөг зарцуулж, 56,943.9 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,618,126.2 мянган төгрөг буюу 97.1 хувьтай байгаа нь цалин хөлс, урамшуулал, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Дээрх зардлуудыг батлагдсан орон тоог бүрэн ажиллуулж чадаагүйгээс дутуу зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 25,827.1 мянга, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 56,404.6 мянга, нийт 82,231.7 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалин хөлс, урамшуулалд 12,830.2 мянга, хог хаягдлыг зайлуулах, ариутгалд 28,694.6 мянга, хоол хүнс, эм, эмнэлгийн хэрэгсэлд 7,589.5 мянга, хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийхэд 10,530.3 мянга, нэг удаагийн тэтгэмжид 22,585.3 мянга, нийт 82,229.9 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 1.8 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 161 мэдээллээс хугацаандаа оруулсан 159 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл байна. Хугацаа хоцроосон болон байршуулаагүй мэдээлэл байхгүй байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 321.0 мянган төгрөгийн төлбөрийн акт, 30,425.9 мянган төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлагыг бүрэн биелүүлсэн байна. Аудитаар өгсөн 298.2 мянган төгрөгийн 3 зөвлөмжийн хэрэгжилт 100.0 хувьтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

/мянган.төг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	321.0	1	321.0			
Албан шаардлага	1	30,425.9	1	30,425.9			
Зөвлөмж	3	298.2	3	298.2			
Нийт дүн	5	31,045.1	5	31,045.1			

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 21,044.8 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 8,090.6 мянган төгрөгийн алдааг залруулж, 12,954.2 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний үнийн өсөлтийг УСНББОУС 17, Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалын 1 дүгээр хавсралтын 4.42 дугаар заалтыг үндэслэн хөрөнгийн дахин үнэлгээний зөрүүгээр бүртгэснийг Сангийн яамны 2021 оны 2 дугаар сарын 5-ны өдрийн 7/406 тоот албан бичгийг үндэслэн бусад орлогоор бүртгэж, тайлагнасныг залруулав.

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 12,954.2 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 4 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Эрүүл мэндийн яамны үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй, 20.0 сая төгрөгийн үнэтэй, 07-35 УНЧ улсын дугаартай, Ниссан Патрол маркийн, 555417 арлын дугаартай суудлын автомашиныг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоол, А-1/3967 тоот албан бичгээр тус төв рүү балансаас балансад шилжүүлжээ. Гэтэл Эрүүл мэндийн яамны эд хөрөнгийг Сүхбаатар дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2018 оны 181/Ш32018/04116 дугаартай захирамжаар битүүмжилсэн тул дээрх автомашиныг эмгэг судлалын үндэсний төвийн нэр дээр шилжүүлэхийг Нийслэлийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газраас зөвшөөрөхгүй байгаа асуудлыг дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1.Татварын үлдэгдлийн данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Татварын нэгдсэн систем дэх татварын ногдуулалт, төлөлтийг шалгаж үзэхэд 2020 оны эцэст 642.6 мянган төгрөгийн татвар илүү төлөлттэй гэж бүртгэгдсэн бол санхүүгийн тайланд өр, авлага бүртгэгдээгүй байна.

1.2. Эрсдэл:

Жилийн эцсийн санхүүгийн тайланд татварын өр, авлага буруу бүртгэгдэснээс алданги, торгууль төлөх эрсдэлтэй.

1.3. Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.7-д заасан “аж ахуйн нэгж, байгууллагын татвар, төлбөр, хураамж, шимтгэлийн тооцооллыг шалгах, тэдгээрт хяналт тавих, мэргэжлийн үйлчилгээний зөвлөгөө туслалцаа авах” гэсэн ерөнхий нягтлан бодогчийн эрх, үүргийн дагуу жилийн эцсийн тайлан гаргахаас өмнө татварын албатай тооцоо нийлж өр, авлага үүсгэхгүй байх.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Сүхбаатар дүүргийн татварын албатай тооцоо нийлж, илүү төлөлтийн шалтгааныг тодруулж, өр авлага үүсэхгүй ажиллана.

2. Биет бус хөрөнгийн элэгдэлтэй холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Биет бус хөрөнгөнд бүртгэлтэй санхүүгийн программ хангамжийн элэгдлийг 809.8 мянган төгрөгөөр дутуу тооцсон байна.

2.2. Эрсдэл:

Санхүүгийн программ хангамжийн ашиглах хугацааг хэтэрхий урт болгосноор элэгдлээрээ анхны өртгөө нөхөх боломжгүй болох эрсдэлтэй.

2.3. Өгсөн зөвлөмж:

“Биет бус хөрөнгийг түүнийг үр ашигтай ашиглах хугацааны туршид системтэйгээр хорогдуулж, хорогдлын хэмжээгээр зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэнэ” гэсэн Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар буюу Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалын 1 дүгээр хавсралтын 4.49 дүгээр заалтыг үндэслэн үр ашигтай ашиглах хугацааг зөв тооцож элэгдүүлэх нь зүйтэй байна.

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Бүртгэлийн программ хангамжийн сайжруулалтыг тогтмол хийлгэж, элэгдүүлэх хугацааг засаж, үр ашигтай ашиглах хугацааг зөв тогтооно.

3.Өөрийн хөрөнгөтэй холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Тус төвийн Засгийн газрын оруулсан капитал буюу өөрийн хөрөнгийн хэмжээ санхүүгийн тайланд 11,401.8 мянган төгрөгөөр зөрүүтэй тусгагдсан байна.

3.2. Эрсдэл:

Улсын бүртгэлийн гэрчилгээн дэх мэдээлэлд орсон өөрчлөлтийг тухай бүрд бүртгүүлээгүйгээс зөрчлийн хуулийн дагуу торгуулах эрсдэлтэй.

3.3. Өгсөн зөвлөмж:

Монгол улсын “Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай” хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т “Энэ хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 10.1-д заасан мэдээлэлд өөрчлөлт оруулах тухай шийдвэр, бусад баримт бичгийг тухайн хуулийн этгээд ажлын 15 өдрийн дотор улсын бүртгэлийн байгууллагад хүргүүлнэ” гэсэн заалтыг үндэслэн өөрийн хөрөнгийн хэмжээг нэмсэн шалтгааныг судалж, зайлшгүй шаардлагаар өөрчлөлт орсон гэж үзвэл Улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглэл хийлгэх нь зүйтэй.

3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Өөрийн эзэмшлийн барилга байгууламжтай холбоотой хөрөнгийн хэмжээ нэмэгдсэн тул Улсын бүртгэлийн гэрчилгээнд хөрөнгийн өөрчлөлтийн бүртгэлийг хийлгэж ажиллана.

Шагнал урамшуулалтай холбоотой асуудал

4.1. Илрүүлэлт:

Ажиллагсдад олгосон 400.0 мянган төгрөгийн шагнал урамшууллыг нийгмийн даатгалын шимтгэлийн тооцоонд хамруулаагүй байна. Дутуу суутгасан шимтгэлийн дүн 100.0 мянган төгрөг байна.

4.2. Эрсдэл:

Нийгмийн даатгалын тухай хууль зөрчигдөх.

4.3. Өгсөн зөвлөмж:

Засгийн газрын 1994 оны 212 дугаар тогтоолоор баталсан “Даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөх, тэтгэвэр, тэтгэмж тогтоолгох хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын бүрэлдэхүүн, дунджийг тодорхойлох журам”-ын 2-т буюу “Нийгмийн даатгалын шимтгэл ногдуулах хөдөлмөрийн хөлсний бүрэлдэхүүнд дараах үндсэн болон нэмэгдэл хөлс, шагналыг оруулж тооцно” гэсэн заалтыг үндэслэн ажиллагсдад олгосон аливаа шагнал урамшууллыг нийгмийн даатгалын шимтгэлд хамруулдаг байх.

4.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Ажиллагсдад олгосон шагналын мөнгийг нийгмийн даатгалын шимтгэл тооцоонд хамруулах болно.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2021-02-18	Аудитын нэр: Эмгэг судлалын үндэсний төвийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код: САГ-2021/65/СТА-
Шалгагдсан байгууллагын нэр:	Эмгэг судлалын үндэсний төв	Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Жилийн эцсийн санхүүгийн тайлан гаргахад харьяа дүүргийн татварын албатай тооцоо нийлээгүйгээс татварын үлдэгдэл зөрсөн	642.6	Зөвлөмж өгсөн	Эмгэг судлалын үндэсний төвийн захирал, ерөнхий нягтлан бодогч	Г.Уянга М.Саранцэцэг
2	Биет бус хөрөнгөнд бүртгэлтэй санхүүгийн программ хангамжийн элэгдлийг буруу тооцсон	809.8	Зөвлөмж өгсөн	Эмгэг судлалын үндэсний төвийн захирал, Ерөнхий нягтлан бодогч	Г.Уянга М.Саранцэцэг
3	Улсын бүртгэлийн гэрчилгээн дэх дүрмийн сангийн хэмжээ санхүүгийн тайлан дахь дүнгээс зөрсөн	11,401.8	Зөвлөмж өгсөн	Эмгэг судлалын үндэсний төвийн захирал, Ерөнхий нягтлан бодогч	Г.Уянга М.Саранцэцэг
4	Зарим ажиллагсдад олгосон шагнал урамшууллаас нийгмийн даатгалын шимтгэл суутгаагүй.	100.0	Зөвлөмж өгсөн	Эмгэг судлалын үндэсний төвийн захирал, Ерөнхий нягтлан бодогч	Г.Уянга М.Саранцэцэг
ДҮН		12,954.2			

